



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн Аудитын газрын 2015 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний
төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН

Ерөнхий дүгнэлт:

БОАЖГ-ын дарга нь тухайн байгууллагын нийт батлагдсан шатахууны зардлын 50,0 орчим хувийг ганцаараа, үүнээс 30,0 гаруй хувийг Улаанбаатарт ажиллахад зарцуулсан байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тайлант оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож төлөвлөж, санхүүжүүлээгүй бөгөөд уг орлогын ихэнх хувийг төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

**Сүхбаатар сум
2015 он**

<u>Тайланг бэлтгэсэн:</u> ҮАГ-ын харьяа Сэлэнгэ аймгийн Аудитын газар Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа Аудитын менежер Б.Батмөнх Шинжээч С.Баасансүрэн Э.Эрдэнэзул 2015 оны 10 сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70362442 дугаарын утас, 70363040 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ:Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ- ын байрны Өргөтгөлд	ТАЙЛАНГИЙН АГУУЛГА Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Хоёр. Үндсэн мэдээлэл Гурав. Аудитын дүн 1. Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын санхүүгийн үйл ажиллагаа үр ашиг, арвилан хэмнэлттэй хэрэгжиж байна уу ? 1.1 Төсвийг үндэслэлтэй төлөвлөж байна уу? 1.2 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнасан эсэх 1.3 Үнэт цаасны орлогыг бүрэн төвлөрүүлж байна уу? 2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байна уу? 2.1 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөж, зарцуулж байна уу? 2.2 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх 2.3 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн санхүүжүүлж байна уу? Дөрөв. Илрүүлсэн зөрчил Тав. Аудитын дүгнэлт Зургаа. Зөвлөмж Холбогдох байгууллагын санал: Саналд өгсөн тайлбар:
--	---

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол улс
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОНХЯ	Байгаль орчин ногоон хөгжлийн яам
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
СТСХ	Санхүү Төрийн сангийн хэлтэс
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БХНС	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх
ТОӨЗ	Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтүүд

1. Аудитын нэр: Сэлэнгэ аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний үр дүн.

2. Аудитын код:
СЭАГ-2015/03-ГА

3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аймгийн Аудитын газрын 2015 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн МУ-ын Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

4. Аудитын зорилт:

Сэлэнгэ аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний үр дүнг шалгаж, дүгнэлт, зөвлөмж өгч, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд гүйцэтгэлийн аудитын зорилт оршив.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэсэн болно.Үүнд:

- ❖ Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын санхүүгийн үйл ажиллагаа үр ашиг, арвилан хэмнэлттэй хэрэгжиж байна уу?
- ❖ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх.

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, санхүүгийн баримтууд, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхээр гаргасан аймгийн ИТХ-ын тогтоол, гүйцэтгэсэн ажлын тайлан, төсвийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тендерийн баримт болон бусад холбогдох материалуудыг хамрууллаа.

6. Аудитын арга зүй:

Аудитын явцад аймгийн БОАЖГ-ын дарга, нягтлан бодогч, эд хариуцагч, аймгийн Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судлах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийн, нотлох зүйл цуглуулан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

7. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

МУ-ын Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, Усны тухай хууль, Төрийн албаны тухай хууль, ТБОНӨХБАҮХА тухай хууль, дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан ЗГ-ын 2000 оны 03-р сарын 30-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”, мөн ЗГ-ын 2014 оны 02-р сарын 14-ний өдрийн 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зохицуулалтын журам” болон бусад холбогдох хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

8. Аудит хийх бүрэлдэхүүн:

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, шинжээч С.Баасансүрэн, Э.Эрдэнэзул нар 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс 11-р дүгээр сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Хоёр. Үндсэн мэдээлэл

Аймгийн БОАЖГ-ын үйл ажиллагаанд 2013 онд 155319,5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 89.94 хувь буюу 139708,5 мянган төгрөгийн санхүүжилт, 2014 онд 438454,1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 93.7 хувь буюу 410794,1 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч бүрэн зарцуулсан байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2013 онд орон нутгийн төсвөөс 507839,2 мянган төгрөгийн, Ойн судалгаа хөгжлийн төвөөс ойн арчилгаа огтлолын ажлын санхүүжилтэнд 21200,0 мянган төгрөгийн нийт 529039,2 мянган төгрөгийг, 2014 онд орон нутгийн төсвөөс 387867,2 мянган төгрөгийн, БОНХЯ-наас ойн арчилгааны огтлолын ажлын санхүүжилтэнд 16080,0 мянган төгрөгийн нийт 403947,2 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

Гурав. Аудитын дүн

БҮЛЭГ 1

Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын санхүүгийн үйл ажиллагаа үр ашиг, арвилан хэмнэлттэй хэрэгжиж байна уу?

Томилолтын хуудас, удирдамж, хийсэн ажлын тайлан зэрэг анхан шатны баримтгүйгээр их хэмжээний санхүүжилтийг 1 хүнд олгосон байна.

1.1 Төсвийг үндэслэлтэй төлөвлөж байна үү ?

Аймгийн БОАЖГ нь 2013 оны төсвийн төслийг боловсруулан 2012 оны 07 сарын 18- ны өдрийн 156 тоот албан бичгээр БОАЖЯ-нд хүргүүлсэн гэх боловч архивын нэгж болгон хадгалаагүй бөгөөд 2014 оны төсвийн төслийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т 2013 оны 07-р сарын 19-ний өдрийн 171 тоот албан бичгээр хүргүүлсэн байна. Тухайн оны батлагдсан төсвийг төсвийн төсөлтэй нь харьцуулсныг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 /мянган төгрөг/

Зардлын төрөл	2014 он		
	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	117601,3	361951,4	244350,1
НДШ	12936,1	39814,6	26878,5
Бичиг хэрэг	1892,8	880,0	1012,8
Шатахуун	18620,0	18620,0	
Шуудан холбоо	4715,8	1316,0	3399,8
Дотоод томилолт	20676,0	6508,7	14167,3
Ном хэвлэл худалдан авах	960,0	168,0	792,0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		750,0	750,0
Урсгал засвар	17750,0	500,0	17250,0
Төлбөр хураамж болон бусад зардал	1218,0	240,	978,0
Эд хогшил худалдан авах	17698,0	1000,0	16698,0
Нормын хувцас зөөлөн эдлэл		451,4	451,4
Байрны түрээс	8000,0	2300,0	5700,0
Сургалт, хурал зөвлөгөөний зардал	4480,0		4480,0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс, төлбөр хураамж	1848,0	569,0	1279,0
Тээврийн хэрэгслийн татвар		285,0	285,0
Нэг удаагийн тэтгэмж урамшил	8218,0	3100,0	5118,0
Дүн	236614,0	438454,1	201840,1

Тус газрын төсвийн төлөвлөлтийг зардлын ангиллаар авч үзвэл:

- ❖ Сумдын байгаль хамгаалагч нарын цалин, НДШ-ийг бодитоор тооцоогүйгээс уг зардлыг 67.5 хувиар бага төсөвлөсөн байна.

- ❖ Бичиг хэргийн зардлыг БОАЖГ болон Ойн албанд зарцуулахаар төлөвлөж зардлыг 2 дахин өсгөж тооцсон.
- ❖ Шуудан холбооны зардлыг захиргаа, Ойн алба, мэргэжилтнүүдийн хэрэгцээнд гэж ангилан бодит зардлыг 2.7 дахин өсгөж тооцсон.
- ❖ Жилд 36 ажилтан томилолтоор ажиллах бөгөөд унааны зардалд 18090,0 мянган төгрөгийг төлөвлөсөн байгаа нь нийт томилолтын зардлын 87.5 хувийг эзэлж үндэслэлгүй болох нь харагдаж байна. Тус газар нь албан ажлын хэрэгцээний автомашинтай боловч нийтийн тээврээр зорчихоор тооцож томилолтын зардлыг хэт өсгөн тооцжээ.
- ❖ Урсгал засварын зардалд барилгын засварыг материал, ажиллах хүчний болон бусад зардлаар нэг бүрчлэн тооцолгүйгээр конторын 1 өрөөг дунджаар 2000,0 мянган төгрөгөөр засварлахаар, автомашины засварын дундаж зардлыг 3000,0 мянган төгрөгөөр тооцсон байна.
- ❖ Байрны түрээсийн төлбөрт жилд 2290,8 мянган төгрөгийг төлөхөөр гэрээтэй боловч уг зардлыг 3.5 дахин өсгөж тооцсон байна.

Дээрх байдлаас харахад тухайн жилийн төсвийн төслийг бодит нөхцөл байдалд үндэслэж бодитоор төсөвлөөгүй байгаа тул цаашид зардлыг бодит нөхцөл байдалд тулгуурлан үнэн зөв тооцоолж хүргүүлж байх нь зүйтэй юм.

1.2 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнасан эсэх

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2012 оны 12-р сарын 04-ны өдрийн 08 дугаар тогтоолоор аймгийн БОАЖГ-ын 2013 оны үндсэн үйл ажиллагааны санхүүжилтийг **129200,0** мянган төгрөгөөр баталсан бол 2013 оны 12-р сарын 04-ны өдрийн 37 дугаар тогтоолоор **155319,5 мянган** төгрөгөөр тодотгож баталсан байна.

Аймгийн БОАЖГ-ын төсөв 2013 онд 155319,5 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 139708,5 мянган төгрөгийн, 2014 онд 438454,1 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 410794,1 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч бүрэн зарцуулсан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2 /мянган төгрөг/

Зардлын төрөл	2013 он		2014 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Үндсэн цалин	102538,8	97470,2	332035,9	311482,8
Унаа хоолны хөнгөлөлт	6553,5	-	13513,5	15990,5
Урамшуулал	6900,0	6886,1	-	-
Бусад нэмэгдлүүд	-	-	16402,0	10599,9
НДШ	12759,3	11590,1	39814,6	37463,0
Бичиг хэрэг	880,0	996,3	880,0	1343,9
Гэрэл, цахилгаан	850,0	850,0	-	-

Түлш, халаалт	1644,0	1644,0	-	-
Байрны түрээсийн зардал	-	-	2300,0	2300,0
Тээвэр, шатахуун	6570,0	6393,7	18620,0	18087,9
Шуудан холбоо	1316,0	1420,1	1316,0	1648,2
Дотоод албан томилолт	6508,7	6286,7	6508,7	6508,5
Ном хэвлэл	168,0	109,8	168,0	76,0
Эд хогшил худалдан авах	1330,0	580,3	1000,0	614,0
Нормын хувцас зөөлөн эдлэл	451,3	-	451,4	-
Урсгал засвар	500,0	-	500,0	611,3
Төлбөр хураамж болон бусад зардал	240,0	1005,6	240,0	64,5
Сургалт, семинарын зардал	750,0	306,4	-	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	750,0	750,0
Бусдаар, гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	524,0	420,0	569,0	741,2
Тээврийн хэрэгслийн татвар	-	-	285,0	287,8
1 удаагийн тэтгэмж, урамшуулал	3100,0	2013,2	3100,0	2224,6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1735,9	1735,9	-	-
Нийт дүн	155319,5	139708,5	438454,1	410794,2

БОАЖГ-ын 2013 оны цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд 115992,3 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 104356,3 мянган төгрөг, НДШ-ийн зардалд 12759,3 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 11590,1 мянган төгрөг тус тус зарцуулжээ.

Цалингийн баримтыг тулган баталгаажуулахад:

- ❖ 2013 онд 104356,3 мянган төгрөгийн цалин хөлс тооцогдож олгосон бөгөөд тус газрын усны мэргэжилтэн, 4-н зам хариуцсан байгаль хамгаалагч нар өндөр насны тэтгэвэрт гарсан, газрын хэвлий хариуцсан мэргэжилтэн жирэмсэн, болон амаржсаны тэтгэмжтэй зэргээс шалтгаалан жилийн эцэст цалингийн сангийн хэмнэлт 5068,6 мянган төгрөг, НДШ-ийн хэмнэлт 1169,1 мянган төгрөг, унаа, хоолны хөнгөлөлтийн хэмнэлт 6553,5 мянган төгрөг, үр дүнгийн урамшууллын хэмнэлт 13,9 мянган төгрөг, нийт 12805,1 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.
- ❖ 2014 онд 311482,8 мянган төгрөгийн цалин тооцогдож олгосон бөгөөд зарим сумдад байгаль хамгаалагч ажиллуулаагүйгээс жилийн эцэст цалин, нэмэгдэл урамшууллын зардлаас 20553,0 мянган төгрөгийн, НДШ-ийн зардлаас 2351,6 мянган төгрөгийн, унаа, хоолны хөнгөлөлтөөс 2151,2 мянган төгрөгийн зэрэг нийт 25055,8 мянган төгрөгийн хэмнэлтийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Тус газар нь аймгийн ЗДТГ-ын өргөтгөлд байрладаг бөгөөд тайлант жилүүдэд батлагдсан төсвийн хуваарийн дагуу гэрэл цахилгаан, түлш халаалт, түрээсийн төлбөр, шатахуун, дотоод албан томилолтын зардлыг зарцуулжээ.

Томилолтын зардлыг анхан шатны баримтаар тулган баталгаажуулахад 2014 онд ажилтнуудад 309,0 мянган төгрөг илүү бодож олгосон нь МУ-ын Сангийн сайдын 2011 оны 06-р сарын 14-ний өдрийн 132 дугаар тушаалын ¹ дэх заалтыг зөрчсөн байна.

Тус газрын албан томилолтын зардал болон томилолтоор ажилласан шатахууны зарцуулалтыг анхан шатны баримтаар тулган баталгаажуулахад дарга Б.Батзориг нь томилолтын удирдамж болон аймгийн Засаг дарга, холбогдох бусад албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан томилолтын хуудасгүйгээр маршрут бичиж их хэмжээний шатахуун зарцуулсан байна. Тодруулбал:

- ❖ 2013 онд тус газрын батлагдсан нийт шатахууны зардлын 48,0 хувь буюу 5845,7 мянган төгрөг, үүнээс Улаанбаатар хотод 13 удаагийн томилолтоор ажилласан гэж маршрут бичиж 3538,1 мянган төгрөгийг ганцаараа зарцуулсан боловч томилолтоор ажилласныг нотлох 2 удаагийн томилолтын хуудсаар 177,5 мянган төгрөг авчээ. */Шатахууны зардлын дэлгэрэнгүйг Хавсралт № 1-д, томилолтын зардлын дэлгэрэнгүйг Хавсралт №-2-т үзүүлэв/*
- ❖ 2014 онд шатахууны нийт зардлын 48,4 хувь буюу 8761,0 мянган төгрөгийн шатахуун, үүнээс Улаанбаатар хот руу сард дунджаар 2 удаа, нийт 23 удаагийн томилолтоор ажилласан гэх маршрут бичиж 5780,9 мянган төгрөгийн шатахууныг мөн ганцаараа зарцуулсан боловч 2 удаагийн томилолтын хуудсаар 71,0 мянган төгрөг авчээ. */Шатахууны зардлын дэлгэрэнгүйг Хавсралт №1-д, томилолтын зардлын дэлгэрэнгүйг Хавсралт №2-т үзүүлэв/*

Өөрөөр хэлбэл сүүлийн 2 жил дараалан бүтэн жилийн батлагдсан шатахууны зардлын 50,0 шахам хувийг ганцаараа хэрэглэсэн байна.

БОАЖГ-ын дарга Б.Батзориг нь томилолтын удирдамж, аймгийн Засаг дарга болон холбогдох бусад албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан томилолтын хуудас зэрэг анхан шатны баримтгүйгээр сар бүр тогтмол 2-3 удаа томилолтоор ажилласан гэж жилийн нийт шатахууны зардлын 50,0 шахам хувийг, Улаанбаатар хотод ажилласан гэж 30,0 гаруй хувийг зөвхөн ганцаараа зарцуулж байгаа нь тус газрын албан томилолтоор ажиллах ажлын 50,0 хувийг ганцаараа гүйцэтгэж, үүний 30,0 гаруй хувь нь Улаанбаатар хотод хэрэгжиж байгаа мэт ойлголтыг төрүүлж байгаа бөгөөд энэ нь тухайн байгууллагын үндсэн зорилго зорилттой нийцэхгүй, үр ашиггүй зарцуулалт болж байна.

Цаашид байгууллагын даргыг томилсон дээд шатны даргын гарын үсэг бүхий албан томилолтын хуудас, ажлын удирдамж зэргийг үндэслэн шатахууны зардлыг олгож байх шаардлагатай байна.

¹ Нэг.Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ тарифийн өөрчлөлттэй уялдуулан улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчдын албан томилолтын зам хоног, байрны зардлын хэмжээг суманд 18000 төгрөг, аймгийн төвд 29000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 35500 төгрөгөөр, төрийн тусгай болон үйлчилгээний албан хаагчийн хувьд зам хоногийн зардлыг суманд 12000 төгрөг, аймгийн төвд 14000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 16000 төгрөгөөр тус тус тоошатахууныцсугай.

1.3 Үнэт цаасны орлогыг бүрэн төвлөрүүлж байна үү?

Аймгийн БОАЖГ нь 2013 онд 1124 ширхэг үнэт цаасны эхний үлдэгдэлтэй байснаас эхний 9 сарын байдлаар 8419,0 мянган төгрөгийн үнэ бүхий 14719 ширхэг үнэт цаасыг худалдан авч, сумдын ойн ангид 9101 ширхэгийг хуваарилж, 6742 ширхэг үнэт цаасны / хуучин загварын / үлдэгдэлтэйгээр тайлагнасан байна.

2014 онд 40 ширхэг үнэт цаасны / шинэ загварын / эхний үлдэгдэлтэй байснаас 18157,0 мянган төгрөгийн үнэ бүхий 18157 ширхэг үнэт цаасыг худалдан авч, сумдын ойн ангид 17017 ширхэгийг хуваарилж, 1180 ширхэг үнэт цаасны үлдэгдэлтэйгээр тайлагнажээ. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3 /эхний 9 сарын байдлаар/

Он	Үнэт цаасны нэр	Эхний үлдэгдэл	Худалдан авсан		Зарцуулсан		Эцсийн үлдэгдэл	Сумдаас татан авсан үнэт цаас
			Тоо ширхэг	Үнэ	Тоо ширхэг	Үнэ		
2013 он	Мод, модон материалын гарал, үүслийн гэрчилгээ	124	4520	4520000	2102	2102000	2542	505
	Хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг	500	1199	1199000	1599	1599000	100	398
	Түлээний мод бэлтгэх эрхийн бичиг	500	9000	2700000	5400	1620000	4100	1563
	Нийт	1124	14719	8419000	9101	5321000	6742	2466
2014 он	Мод, модон материалын гарал, үүслийн гэрчилгээ	40	6000	6000000	5760	5760000	280	280000
	Мод бэлтгэх эрхийн бичиг	-	12157	12157000	11257	11257000	900	900000
	Нийт		18157	18157000	17017	17017000	1180	1180000

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2013 оны 5-р сарын 15-ны өдрийн А-153 тоот тушаалаар “Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журам” болон “Мод модон материалын гарал, үүслийн гэрчилгээ, ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг”-ийн загвар өөрчлөгдсөн байна. Үүнтэй холбоотойгоор аймгийн БОАЖГ нь 6742 үнэт цаасны үлдэгдэл дээр сумдаас 2466 ширхэг хуучин загварын үнэт цаасыг эргүүлэн татан авч

2013 оны 10-р сарын 15-нд БОНХЯ-д тушаан шинэ загварын 1500 ширхэг мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ, 5500 ширхэг мод бэлтгэх эрхийн бичиг зэрэг нийт 3150,0 мянган төгрөгийн үнэт цаас авсан байна.

Тус газар нь 2013 онд БОНХЯ-аас 6326,0 мянган төгрөгийн үнэт цаасыг худалдан авч, 6325,1 мянган төгрөг, 2014 онд 18157,0 мянган төгрөгийн үнэт цаасыг худалдан авч 18157,0 мянган төгрөгийг тус тус “Байгаль хамгаалах сан”-гийн 900013040 тоот дансанд тус тус төвлөрүүлсэн байна.

Тайлант онуудад үнэт цаасны орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 2

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын дийлэнхийг төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

2.1 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөж, зарцуулж байна уу?

“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлого” -ыг МУ-ын Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.2²-т заасан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдүүлж мөн хуулийн 18.1³-д заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээнд төлөвлөж, санхүүжүүлэхээр заасан байдаг.

Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсвийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2013 онд **3358736,7 мянган** төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр **3132056,4 мянган** төгрөгийг, 2014 онд **2271207,4 мянган** төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр **2487799,0 мянган** төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Аймгийн төсвийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, түүнээс бүрдүүлсэн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилтийг он тус бүрээр хүснэгтлэн харуулбал:

² Төлбөрийн орлогын хэсгийг дор дурдсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдэнэ: 13.2.1.байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого, 13.2.2.ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого, 12.2.3.ойн нөөц ашигласны төлбөрийн орлого, 13.2.4.ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого, 13.2.5.газрын нөөц төлбөрийн орлого

³ Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно: 1.Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлого 30 хувь 2.Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын орлого 50 хувь 3.Газрын нөөц ашигласны төлбөрийн орлого 30 хувь 4.Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 85 хувь 5.Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 55 хувь

Он	Төлөвлөгөө			Гүйцэтгэл		
	БНАТ-ийн нийт орлого	БОХББНС арга хэмжээд төлөвлөвөл зохих	БОХББНС арга хэмжээнд төлөвлөсөн	БНАТ-ийн нийт орлого	БОХББНС арга хэмжээг санхүүжүүлбэл зохих	БОХББНС арга хэмжээг санхүүжүүлсэн
2013 он	3358736,7	1502666,9	722800,0	3132056,4	1379649,5	668700,0
2014 он	2271207,4	1323363,4	589000,0	2487799,1	1457448,5	385383,6

Хүснэгтээс харахад 2013 онд аймгийн төсвийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн нийт орлогыг 3358736,7 мянган төгрөгөөр, үүнээс байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийн нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 722800,0 мянган төгрөгөөр төлөвлөсөн нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар тогтоосон хувь хэмжээнээс даруй 2,0 дахин бага байгаа бөгөөд төлөвлөхөөс эхлээд уг хуулийг зөрчихөд хүргэсэн байна. Гүйцэтгэлээр байгалийн нөөц ашигласны орлого болох 3132056,4 мянган төгрөгөөс дээрх арга хэмжээнд **1379649,5 мянган** төгрөг зарцуулах ёстой атал **668700,0 мянган** төгрөг зарцуулж тогтоосон хувь, хэмжээнээс мөн л 2,1 дахин бага хөрөнгө зарцуулсан байна.

2014 онд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийн нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг тогтоосон хувь хэмжээнээс 2,2 дахин багаар төлөвлөж, санхүүжүүлэхдээ 3,8 дахин багаар / байгалийн нөөц ашигласны татварын орлогын дөнгөж 26,4 хувьтай тэнцэх / гүйцэтгэжээ.

Өөрөөр хэлбэл байгалийн баялаг ашигласнаас орох орлогоос байгаль хамгаалах, ашигласан газрыг нөхөн сэргээхэд тодорхой хэмжээний хөрөнгийг зарцуулахаар хуульчилсан байхад дээрх орлогын дийлэнх хувийг төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулж иржээ. Иймээс цаашид нэгэнт байгалийн баялаг ашиглаж орлого төвлөрүүлсэн бол ашигласан газрыг нөхөн сэргээх, байгаль хамгаалах арга хэмжээнд тухайн орлогоос хуульчилсан хувиар тооцон зарцуулахаар төлөвлөж, санхүүжүүлж байх нь зүйтэй юм.

2013 онд байгаль хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээнд зориулсан эх үүсвэрээр гүйцэтгэхээр төлөвлөж, санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг дараах хүснэгтээр харуулбал:

Д/д	Арга хэмжээний нэр	Төлөвлөсөн	Санхүүжүүлсэн
1	Ойжуулалт хийх /800 га-д /	160000,0	159945,4
2	Өмнөх жилийн ойжуулсан талбайд арчилгаа хамгаалалт хийх /1180 га-д /	94400,0	93200,0

3	Мод үржүүлгийн газар, байгуулах өргөтгөх /3 газар байгуулах/	30000,0	30000,0
4	Үрийн талбай тусгаарлах / 5 /	2500,0	2500,0
5	3 автомашины урсгал засварт /БОГ/	20000,0	19995,8
6	МХГ-ын автомашины засварт	20000,0	20000,0
7	Тавилга, эд хогшил худалдан авах	9500,0	9486,8
8	Агнуур зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөө боловсруулах	30000,0	-
9	Ойд арчилгаа цэвэрлэгээ хийх	Сургалт	1300,0
		Ойн арчилгаа /2/	2600,0
10	Булаг шандны эхийг тохижуулах / 2 булаг/	4000,0	3000,0
11	БОАЖГ-т автомашин худалдан авах	40000,0	40000,0
12	МХГ-т автомашин худалдан авах	40000,0	40000,0
13	Arc Gis 10.0.1 программ хангамж худалдан авах, программ хангамжийн сургалтанд хамрагдах /1 /	11800,0	11500,0
14	Ойн нөхөрлөлүүдийн ойн санд зохион байгуулалт хийх зардал/ 30000 га /	3000,0	3000,0
15	Тусгай хамгаалалтын газрын орчны бүсийг хөгжүүлэх /Тужийн нарс улсын тусгай хамгаалалттай газар /	3400,0	-
16	Загасны нөөц тогтоон хамгаалах, зохистой ашиглах төлөвлөгөө боловсруулах /1 /	15000,0	-
17	Ерөө суман дахь ойн ангид автомашин худалдан авах	30000,0	30000,0
18	Бичиг хэргийн зардалд	500,0	-
19	Шуудан холбооны зардалд	500,0	-
20	Шатахууны зардалд	5000,0	5000,0
21	Иж бүрэн хувцас /өвөл, зуны/	7500,0	7500,0
22	Мандал суман дахь Ойн ангид багаж хэрэгсэл авах	7600,0	7600,0
23	Сүхбаатар суман дахь Ойн ангид багаж хэрэгсэл авах	7500,0	7500,0
24	Баруунбүрэн суман дахь Ойн ангид багаж хэрэгсэл авах	5100,0	5100,0
25	Ерөө суман дахь Ойн ангид багаж хэрэгсэл авах	7600,0	7600,0
26	Сүхбаатар сумын төвлөрсөн хогийн цэгт дугуйт ачигч худалдан авах/ 1 /	33000,0	33000,0
27	Уур амьсгалын өөрчлөлтийн хөгжлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх / 1 /	3000,0	3000,0
28	Буурын голын нүхэн гүүрний орчмын урсацыг нэмэгдүүлэх	98000,0	97436,1
29	Сүхбаатар сумын ногоон байгууламжийн усалгаанд зориулж усны машин /5тн/	30000,0	30000,0
НИЙТ ДҮН		722800,0	665444,1

2013 онд “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ”-ний санхүүжилтээр хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-ын 2012 оны 12-р сарын 04-ний өдрийн 08 дугаар тогтоолоор анх **1912100,0 мянган** төгрөг баталсан бол 2013 оны 03-р сарын 21-ны өдрийн 14 тоот тогтоолоор 417700,0 мянган төгрөгийн төсөв бүхий 19 төсөл арга хэмжээг нэмж, 350000,0 мянган төгрөгийн төсөвтэй ажлыг 30,3 хувиар багасган нийт **2085800,0 мянган** төгрөгөөр, 2013 оны 12-р сарын 04-ны өдрийн 37 тоот тогтоолоор уг арга хэмжээний төсвийг 2,8 дахин буюу 1363000,0 мянган төгрөгөөр бууруулж **722800,0 мянган** төгрөгийн 29 арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний санхүүжилтээр 2013 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Ерөө, Хүдэр суманд ашиглаж байгаад орхигдсон газарт мэргэжлийн байгууллагаар нөхөн сэргээлт хийлгэх, ойн хөнөөлт шавьжтай тэмцэх, булаг шандны эхийг тохижуулах, аймгийн хэмжээнд ургамлын судалгаа хийх, түймрийн тархалтаас урьдчилан сэргийлэх зурвас татах, хууль бусаар ашигт малтмал олборлосны улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг тооцох, ойн зурвас байгуулах зэрэг байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаануудыг нь хасч аймгийн БОАЖГ болон МХГ-т автомашин худалдан авах, автомашинуудад урсгал засвар хийх, БОАЖГ-т тавилга эд хогшил, нормын хувцас худалдан авах, шатахууны зардлыг нэмэх зэрэг урсгал зардлуудыг батлан санхүүжүүлсэн байна.

2014 онд байгаль хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээнд зориулсан эх үүсвэрээр гүйцэтгэхээр төлөвлөж, санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6 /мянган төгрөг/			
Д/д	Арга хэмжээний нэр	Батлагдсан төлөвлөгөө	Санхүүжүүлсэн
1	Мод бэлтгэсэн болон ой хээрийн түймэр, хөнөөлт шавьжид нэрвэгдсэн талбайд ойжуулалт хийх/ 500 га /	347500,0	170266,4
2	Элсний нүүлт, цөлжилтөөс сэргийлэх зорилгоор Орхон, Жавхлант, Баянгол сумдад хамгаалалтын ногоон зурвас байгуулах/ 10 га /	11000,0	11000,0
3	Алтанбулаг суманд цөлжилт үүссэн талбайг хашиж, хамгаалан навчит ногоон модоор ойжуулалт хийх / 9 га /	5000,0	5000,0
4	Цагааннуур, Орхонтуул, Жавхлант, Зүүнбүрэн, Сант сумдад мод үржүүлгийн газар байгуулах / 5 /	50000,0	16650,0
5	Мандал суманд үрийн байнгын талбай тусгаарлах ажлыг хийх / 10 /	5000,0	5000,0
6	Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх тэмцлийн ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх / 8800 /	88000,0	86300,0
7	Ойн байгууллагын 90 жилийн ойд зориулсан ном хэвлүүлэх	2500,0	2500,0
8	Гэрэлжүүлэх огтлолыг Алтанбулаг, Хушаат, Хүдэр, Түшиг сумдад хийх /100 га /	5300,0	5300,0
9	Анх удаа ойн санг гэрээгээр эзэмшиж буй нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах / 29545 га /	3300,0	3300,0
10	Цагааннуур, Мандал, Сант, Жавхлант сумдад булаг шандын эхийг тохижуулах / 5 /	10000,0	10000,0
11	Байгаль хамгаалах сарын аян зохион байгуулж, сурагчдын дунд уралдаан зарлан урамшуулах/ 2 удаа /	1000,0	1000,0
12	Агнуур зохион байгуулалтын ажлыг Алтанбулаг, Хүдэр, Ерөө, Мандал, Баянгол сумдад хийх / 1 /	45000,0	38017,4
13	Байгаль хамгаалагчдын зөвлөгөөн зохион байгуулах / 1 /	3200,0	3200,0
14	Байгаль орчны газрын цахим хуудас хийлгэх/ 1 /	2000,0	2000,0
15	Байгаль хамгаалах сурталчилгааны самбарыг Алтанбулаг, Баруунбүрэн, Баянгол, Сүхбаатар, Шаамар суманд байрлуулах/ 6 ш /	7200,0	7200,0

16	Байгаль орчны чиглэлээр зөвлөмж, нугалбар, санамж боловсруулан хэвлүүлэх / 20000 ш /	3000,0	3000,0
НИЙТ ДҮН		589000,0	369733,8

Аймгийн ИТХ-ын 2013 оны 12-р сарын 04-ний өдрийн 38 тоот тогтоолоор 2014 онд “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ”-ний санхүүжилтээр 25 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр **883600,0 мянган** төгрөг баталсан бол 2014 оны 07-р сарын 07-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор **1131000,0 мянган** төгрөг болгон нэмэгдүүлж, 2014 оны 12-р сарын 04-ний өдрийн 58 дугаар тогтоолоор **604900,0 мянган** төгрөг болгон, 2014 оны 12-р сарын 22-ний өдрийн 60 дугаар тогтоолоор **589000,0 мянган** төгрөг болгон бууруулж баталсан байлаа.

Тухайн онд онд хэрэгжүүлэхээр анх төлөвлөсөн бүх нийтээр мод тарих өдрийг хавар, намрын улиралд зохион байгуулж, ногоон төгөл, ногоон байгууламжтай айл өрх, албан байгууллага, иргэдийг урамшуулах, сум дундын ойн ангийг чадавхижуулах сургалт зохион байгуулах, уур амьсгалын өөрчлөлтийн бодлого боловсруулан хэрэгжүүлэх, арчилгааны огтлолын сургалт зохион байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг хасч, аймгийн БОАЖГ-т цахим хуудас хийх, ойн салбарын 90 жилд зориулсан ном хэвлүүлэх зэрэг төсөл, арга хэмжээг нэмж санхүүжүүлсэн байна.

Ингэж 2013-2014 онуудад байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний санхүүжилтээр хуулийн дагуу санхүүжүүлэх арга хэмжээнүүдийг хасч, эд хогшил, авто машин худалдан авах, засварлах, ой тэмдэглэх, цахим хуудас хийх, шатахууны зардал зэрэг урсгал зардлуудыг санхүүжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлсэн нь ЗГ-ын 2014 оны 02-р сарын 14-ний өдрийн 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын ын 3.5⁴ 3.3.1⁵, 3.3.4⁶ дэх заалтуудыг зөрчсөн байна.

2.2 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх

Аймгийн Засаг даргын 2013 оны А/247 тоот захирамжаар автомашин болон тавилга эд хогшил худалдан авах, автомашинд засвар хийлгэх зэрэг 69500,0 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг аймгийн БОАЖГ-т,

⁴ Энэ журмын 3,4 дүгээр зүйлд заасны дагуу бүрдүүлсэн төлбөрийн орлогын хэсэгтэй тэнцэх хөрөнгийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг арвижуулах, нөхөн сэргээх, зохион байгуулах болон орчны доройтлыг бууруулах, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, байгаль орчны хууль тогтоомжийг сахиулах арга хэмжээнд зарцуулна

⁵ Аймаг болон тухайн сумын ой зохион байгуулалт хийх, ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх арга хэмжээ авах, нөхөрлөл, ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг дэмжих

⁶ Ойн үр бэлтгэх ой сонгох, плантаци байгуулах, үр, боргоцой бэлтгэж боловсруулах, тарьц, суулгац ургуулах, ойг нөхөн сэргээх, тарьж ургуулах, байгалийн сэргэн ургалтад туслах, ойн зурвас, модлог ургамлын цэцэрлэг байгуулах, голын эх, эрэг дагуу иод тарьж төгөл байгуулах, баянбүрд бий болгох, хууль бус мод бэлтгэх зөрчлийг бууруулах, хяналт шалгалт хийх арга хэмжээнд тус тус зарцуулна.

автомашин, багаж хэрэгсэл худалдан авах 37600,0 мянган төгрөгийн ажлыг Ерөө суман дахь сум дундын ойн ангид тус тус эрхийг шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2013 оны А/256 тоот захирамжаар автомашин худалдан авах, засвар хийлгэх зэрэг 60000,0 мянган төгрөгийн арга хэмжээг гүйцэтгэх эрхийг аймгийн МХГ-т, 2013 оны А/269 тоот захирамжаар 33000,0 мянган төгрөгийн өртөгтэй хог ачигч худалдан авах эрхийг Сүхбаатар сумын Засаг даргад, 449100,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 9-н төсөл, арга хэмжээг гүйцэтгэх эрхийг БОАЖГ-т тус тус шилжүүлсэн байна.

“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ”-ний зардлаар 2013 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 29 төсөл, арга хэмжээнээс 20 нь бүрэн хийгдэж, тендерийг оройтож зарласнаас 2 ажил дараа онд гүйцэтгэгдэн, санхүүжилт хүрэлцэхгүйн улмаас 4 ажил огт хийгдээгүй байна.

Аймгийн БОАЖГ-т эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээнээс 160000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “800 га талбайд ойжуулалт хийх”, 98000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Буурын голын нүхэн гүүрийн орчмын усны урсацыг нэмэгдүүлэх, гол орчмын намагжилтийг багасгах зорилгоор нүхэн гүүрийг өөрчлөх” ажлуудын гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар сонгосон байна.

Аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар байгуулагдсан “Үнэлгээний хороо” нь “800 га талбайд ойжуулалт хийх” ажлыг хийгдэх ажлын хэмжээ, газар зүйн байрлалаас хамааруулан 7 багц болгон гүйцэтгэгчийг сонгох эхний удаагийн нээлттэй тендерт шалгаруулалтад ирүүлсэн бүх тендер шаардлага хангаагүй тул татгалзаж, дахин тендер зарласан байна. Хоёр дахь удаагийн нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч, гүйцэтгэгчээр шалгарсан аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №7 /мянган төгрөг/

Д/д	Ойжуулалтын хийгдэх сумын нэр, багц №	Х/н	Тоо	Тендерт оролцогчид	Тендерт ялагч	Төсөвт өртөг	Гэрээний үнэ
1	Алтанбулаг сум “Амгалан толгой” Багц №1	Га	150	Багц 1- 1.“Өргөн Сэлэнгэ” ХХК 2.“Ойн ан” төв, “Ойн хүрэм” ХХК- түншлэл	“Өргөн Сэлэнгэ” ХХК	30000,0	29946,3
	Алтанбулаг сум “Их Дүгэрээн урд тал” Багц №2	га	150	Багц 2- “Сэлэнгэ Бугант” ХХК	“Сэлэнгэ Бугант” ХХК	30000,0	30000,0
	Алтанбулаг сум “Их Дүгэрээн урд тал” Багц №3	Га	150	Багц 3- “Буюн Од” ХХК	“Буюн Од” ХХК	30000,0	30000,0
	Алтанбулаг сум “Их Дүгэрээн урд тал” Багц №4	Га	150	Багц 4-“Бугант гол” ХХК	“Бугант гол” ХХК	30000,0	30000,0
	Алтанбулаг сум “Их Дүгэрээн урд тал” Багц	Га	150	Багц 5- “Сосна” ХХК	“Сосна” ХХК	30000,0	30000,0

	№5						
	Алтанбулаг сум “Их Дүгэрээн урд тал” Багц №6	Га	20	Багц 6-“Ивцэг ой” ББН	“Ивцэг ой” ББН	4000,0	3994,0
	Ерөө сум “Баянгол” Багц №7	Га	30	Багц 7-“Бугант Минж” ХХК	“Бугант Минж” ХХК	6000,0	5999,8
2	Буурын голын нүхэн гүүрний орчмын урсацыг нэмэгдүүлэх	-	-	1.“Сэлэнгэ есөн Эрдэнэ” ХХК 2.“АТД” ХХК	“Сэлэнгэ Есөн Эрдэнэ” ХХК	98000,0	97436,1
	НИЙТ ДҮН					258000,0	257376,2

Үнэлгээний хороо нь худалдан авах ажиллагааны явцад хуулинд заасан материалыг бүрэн ирүүлээгүй дараах компаниудыг сонгон шалгаруулсан байна. Үүнд:

- ❖ Тус ажлын 1-р багцын гүйцэтгэгчээр шалгарсан “Өргөн Сэлэнгэ” ХХК нь компаний захирал, уг ажлыг хариуцаж ажиллах ойн инженерийн сургууль төгссөн диплом гэрчилгээний хуулбар, харьяалагдах банкны тодорхойлолт, түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн зэргийг ирүүлээгүй байна.
- ❖ Тус ажлын 2-р багцад шалгарсан “Сэлэнгэ Бугант” ХХК нь санхүүгийн тайлан, түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн, компаний захирал, уг ажлыг хариуцаж ажиллах ойн инженерийн сургууль төгссөн диплом, гэрчилгээний хуулбар зэргийг ирүүлээгүй байна.
- ❖ Тус ажлын 3-р багцад шалгарсан “Буян-Од” ХХК нь түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн, компаний захирал, уг ажлыг хариуцаж ажиллах ойн инженерийн сургууль төгссөн диплом гэрчилгээний хуулбарыг ирүүлээгүй байна.
- ❖ Тус ажлын 4-р багцад шалгарсан “Бугант гол” ХХК нь түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн, компаний захирал, уг ажлыг хариуцаж ажиллах ойн инженерийн сургууль төгссөн диплом гэрчилгээний хуулбарыг байна.
- ❖ Тус ажлын 5-р багцад шалгарсан “Сосна” ХХК нь түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт , компаний захирал, уг ажлыг хариуцаж ажиллах ойн инженерийн сургууль төгссөн диплом гэрчилгээний хуулбарыг ирүүлээгүй байна.
- ❖ Тус ажлын 6-р багцад шалгарсан “Ивцэг Ой” ББН нь түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг ирүүлээгүй байна.
- ❖ Тус ажлын 7-р багцад шалгарсан “Бугант Минж” ХХК нь түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дүн, компаний захирлын судалгаа, сургууль төгссөн диплом гэрчилгээний хуулбарыг ирүүлээгүй байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын 2013 оны 03-р сарын 29-ний өдрийн А-96/71 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх,

улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”-ын 4.7⁷ дахь заалтын дагуу 94400,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Өмнөх жилийн ойжуулсан талбайд арчилгаа, хамгаалалт хийх” төсөл арга хэмжээг өмнөх жилд ойжуулалтын ажлыг гүйцэтгэсэн аж ахуйн нэгж, иргэдтэй ойжуулалт хийгдсэн талбай бүрээр 9 багцад хуваан шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2013 оны А/367 тоот захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж БОХНС арга хэмжээний зардлаар тус онд гүйцэтгэсэн ойжуулалт, ойн үрийн талбай тусгаарлах, мод үржүүлгийн газар байгуулах /3/, булаг, шанд тохижуулах /2/, 2012 онд ойжуулсан талбайн арчилгаа, хамгаалалт хийх ажлуудын гүйцэтгэлийг хүлээн авсан байна. Үүнээс “Булаг шандын эхийг тохижуулах - Шаамар сумын Дулаанхаан тосгоны Рашааны амын булаг” /2000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй/ ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан иргэн П.Сайнбаяр нь гэрээний хугацаанд ажлаа комисст хүлээлгэж өгөөгүй тул үлдэгдэл 50 хувийн санхүүжилтийг олгоогүй, тус ажлыг актаар хүлээж аваагүй байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2013 онд санхүүжүүлсэн 30000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Ерөө суман дахь ойн ангид автомашин худалдан авах” ажлын худалдан авах ажиллагааны баримт материалыг аудитын явцад ирүүлээгүй учир худалдан авах ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгээгүй гэж үзээд зөрчлөөр тооцов.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2014 онд санхүүлэхээр төлөвлөсөн нийт 16 ажлаас 14 нь бүрэн хэрэгжиж, 2 ажлыг комиссын актаар хүлээлгэж өгөөгүй байна.

Үүнээс 347500,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Мод бэлтгэсэн болон ой хээрийн түймэр, хөнөөлт шавьжид нэрвэгдсэн 500 га талбайд ойжуулалт хийх”, 88000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх” ажлуудын гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 45000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Агнуур зохион байгуулалтын ажлыг Алтанбулаг, Хүдэр, Ерөө, Мандал, Баянгол сумдад хийх” ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгосон байна.

Үнэлгээний хороо нь “Мод бэлтгэсэн болон ой хээрийн түймэр, хөнөөлт шавьжид нэрвэгдсэн 500 га талбайд ойжуулалт хийх” ажлыг хийгдэх ажлын хэмжээ, газар зүйн байрлалаас хамааруулан 7 багц болгон гүйцэтгэгчийг сонгох эхний удаагийн нээлттэй тендерт шалгаруулалтад ирүүлсэн бүх тендер шаардлага хангаагүй тул татгалзаж, дахин тендер зарласан байна. Хоёр дахь удаагийн нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч, гүйцэтгэгчээр шалгарсан аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №8 /мянган төгрөг/

Д/д	Ойжуулалт хийгдэх сумын нэр, багц №	Х/н	Тоо	Тендерт оролцогч	Тендерийн Ялагч	Төсөвт өртөг	Гэрээний үнэ
-----	-------------------------------------	-----	-----	------------------	-----------------	--------------	--------------

⁷ Ойжуулалт, ойн зурвас төгөл байгуулах, ойг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэсэн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ойжуулсан талбайгаа 3 жилийн хугацаанд арчлан хамгаалж ургуулах бөгөөд энэ үзүүлэлтийг дараагийн ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулахад нэг шалгуур болгоно.

1	Баруунбүрэн сум Багц №3	Га	150	1.Ойн ан төв ХХК, Ойн хүрэм ХХК- иудын түншлэл 2.Сэлэнгэ бугант ХХК	Ойн ан төв ХХК, Ойн хүрэм ХХК-иудын түншлэл	104250,0	100485,9
2	Сант сум №4	Га	100	1.Ойн ан төв ХХК, Ойн хүрэм ХХК- иудын түншлэл		69500,0	67925,2
3	Зүүнбүрэн сум 90 Багц №1	Га	90	1.Өргөн сэлэнгэ ХХК	Өргөн сэлэнгэ ХХК	62550,0	61855,5
4	Шаамар, Жавхлант сумдад Багц №7	Га	65			45175,0	44526,2
Нийт дүн			405			281475,0	274792,8

Дээрх ойжуулалтын ажлын нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулсан үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийн ТООЗ-нд заасан зайлшгүй шаардлагатай баримт материалыг ирүүлээгүй аж ахуйн нэгжүүдийг гүйцэтгэгчээр шалгаруулсан байна. Үүнийг тодруулбал:

- ❖ Баруунбүрэн, Сант сумын ойжуулалтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Ойн ан төв” ХХК, “Ойн хүрэм” ХХК-иудын түншлэл нь нотариатаар батлуулсан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрээний хуулбар, банк, татвар, шүүх эсвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын тодорхойлолтуудын эх хувь, ойжуулалтын ажлыг хариуцаж ажиллах ойн инженерийн НД-ын дэвтрийн хуулбарыг ирүүлээгүй бөгөөд аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг дутуу ирүүлсэн байна.
- ❖ Зүүнбүрэн, Шаамар, Жавхлант сумдын ойжуулалтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Өргөн сэлэнгэ” ХХК нь нотариатаар баталгаажуулсан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрээний хуулбар, банкны харилцах дансны хуулга, ойжуулалтын ажлыг хариуцаж ажиллах ойн инженерийн НД-ын дэвтрийн хуулбар, хийж гүйцэтгэсэн ажлын гэрээг нотариатаар баталгаажуулсан хуулбар, ерөнхий инженерийн мэдээлэлийг ирүүлээгүй байна. /Тус компани нь ойн инженергүй зөвхөн компанийн захирлын мэдээллийг ирүүлсэн /

Ойжуулалтын ажлын 2 дахь удаагийн нээлттэй тендер шалгаруулалтаар 1,3,4,7 дахь багц ажлуудын гүйцэтгэгчийг сонгон гэрээ байгуулсан бол оролцогч ирээгүй 2,5,6 дахь багц ажлуудыг шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгүүлэхээр үнэлгээний хорооноос шийдвэрлэжээ. Энэхүү шийдвэрийн дагуу эрх бүхий 2 компанид үнийн санал ирүүлэх урилгыг явуулсан бөгөөд 2 болон 5 дахь багц ажлуудыг “Бугант номин” ХХК нь 55360,0 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр үнийн санал ирүүлснээр, 6 дахь багц ажлыг “Бугант минж” ХХК нь 10380,0 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр санал ирүүлснээр тус тус гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ.

Ойжуулалтын ажлын нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулсан, урьдчилгаа санхүүжилтийг оройтож олгосон хэдий ч гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд өөрсдийн хөрөнгөөр ойжуулалтын ажлыг 2014 ондоо багтаан гүйцэтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2015 оны 06-р сарын 09-ний өдрийн А/262 тоот захирамжаар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2014 онд хийгдсэн ойжуулалтын ажлын гүйцэтгэлийг хүлээн авах комиссыг 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Ажил хүлээн авах комисс нь аймгийн БОАЖГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2015 оны 10-р сард ойжуулалтын ажлыг газар дээр нь шалгасан бөгөөд “Ойжуулалтын ажлыг хүлээж авсан акт” баталгаажих шатандаа байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар санхүүжүүлэх 88000,0 мянган төгрөгийн төсөвтэй “Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх тэмцлийн ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх” ажил, 45000,0 мянган төгрөгийн төсөвтэй “Сэлэнгэ аймгийн хэмжээнд агнуур зохион байгуулалт, менежмент төлөвлөгөө боловсруулах” ажлын гүйцэтгэгчид гэрээт хугацаанд ажлаа гүйцэтгэн хүлээлгэн өгсөн байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний санхүүжилтээр 2013 онд нийт 98400,0 мянган төгрөгийн төсөвтэй 10 ажил, 2014 онд нийт 108500,0 мянган төгрөгийн төсөвтэй 13 төсөл арга хэмжээг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №3-д үзүүлэв/

“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ”-ний зардлаар 2014 онд хэрэгжүүлсэн 16 арга хэмжээнээс 14 –г нь комиссын актаар хүлээлгэн өгсөн бол ойжуулалт, мод үржүүлгийн газар байгуулах 2 ажлыг комиссын актаар хүлээлгэж өгөөгүй байна. 2014 оны намар ойжуулалтын ажил хийгдсэн тул тарьц, суулгацын амьдралтыг нэг жилийн дараа дараа оны намар хүлээн авахаар шийдвэрлэсэн байна.

Хэдийгээр байгаль орчныг хамагалах, нөхөн сэргээх арга хэмжээний санхүүжилтээр хийгдсэн худалдан авах ажиллагааны дийлэнхийг гэрээт хугацаанд ашиглалтад хүлээн авсан боловч сонгон шалгаруулалт явуулахдаа холбогдох баримт материалыг бүрэн бүрдүүлээгүй байна. Иймээс цаашид ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 14-16 дугаар зүйл, тендерийн баримт бичгийн ТООЗ-нд заасан зайлшгүй шаардлагатай баримт материалын бүрдэл, бусад шаардлагыг хангасан аж ахуйн нэгжүүдийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

2.3 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн санхүүжүүлсэн байна үү?

“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ”-ний эх үүсвэрээр санхүүжүүлэхээр 2013 онд нийт 722800,0 мянган төгрөгийн төсөвтэй 29 ажил, 2014 онд 589000,0 мянган төгрөгийн төсөвтэй 16 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аас баталсан байна. Дээрх арга хэмжээнээс 2013 онд 30000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Агнуур зохион байгуулалт, менежмент төлөвлөгөө боловсруулах”, 15000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Загасны нөөц тогтоон хамгаалах, зохистой ашиглах, төлөвлөгөө боловсруулах” төсөл арга хэмжээний санхүүжилт хүрэлцээгүйгүйгээс худалдан авах ажиллагааг 11-р сард зохион байгуулснаас уг ажил хийгдэж амжаагүй тул 2014 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан бол 3400,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Тусгай хамгаалалттай газрын орчны

бүсийг хөгжүүлэх /Тужийн нарс улсын тусгай хамгаалалттай газар/” төсөл арга хэмжээг санхүүжилт хүрэлцэхгүйн улмаас хэрэгжүүлээгүй байна.

Мөн онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 2600,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Ерөө, Мандал сумын нутагт тус бүр 25 га талбайд арчилгааны огтлолт /тохируулах/ хийх ажлыг сум дундын ойн ангиуд 11-р сард комисст хүлээлгэн өгсөн боловч тайлан мэдээ, ажил хүлээлгэн өгсөн актыг тайлант онд ирүүлээгүй тул үлдэгдэл 520,0 мянган төгрөгийн санхүүжилтийг 2014 онд олгосон байна.

БОХНС арга хэмжээний санхүүжилтээр 2014 онд хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аар баталсан 16 төсөл арга хэмжээнээс 347500,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Мод бэлтгэсэн болон ой хээрийн түймэр, хөнөөлт шавьжид нэрвэгдсэн 500 га талбайд ойжуулалт хийх”, 50000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Цагааннуур, Орхонтуул, Жавхлант, Зүүнбүрэн, Сант сумдад мод үржүүлгийн газар байгуулах” ажлуудын санхүүжүүлтийг дутуу олгосон байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №9 /мянган төгрөг /

Д/д	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэгч	Ажил эхлэх дуусах	Гэрээний үнэ	Санхүүжилтийн байдал	
					Урьдчилгаа санхүүжилт	Дутуу санхүүжилт
Шилмүүст модоор ойжуулалт хийх						
1	Баруунбүрэн, Сант сумдад /Багц №3, №4/	Ой ан төв ХХК, Ойн хүрэм ХХК- иудын түншлэл	08.07- 10.05	168411,1	84205,5	84205,5
2	Зүүнбүрэн, Шаамар, Жавхлант сумдад /Багц №1, № 7/	Өргөн сэлэнгэ ХХК	08.08- 10.05	106381,6	53190,8	53190,8
3	Баянгол, Орхонтуул сумдад /Багц №2, №5/	Бугант номин ХХК	09.03- 10.05	55360,0	27680,0	27680,0
4	Сүхбаатар, Орхон сумдад /Багц № 6/	Бугант минж ХХК	09.08- 10.05	10380,0	51900,0	51900,0
	Ойжуулалтын ажлын дүн			340532,8	170266,4	170266,4
Сумдад мод үржүүлгийн газар байгуулах						
1	Жавхлант суманд	Моностой багийн иргэн Ц.Сүхбат	05.19- 10.25	10000,0	3330,0	6670,0
2	Орхонтуул суманд	Баянцогт багийн иргэн Б.Оюунсайхан	05.19- 10.25	10000,0	3330,0	6670,0
3	Цагааннуур суманд	Хуурч багийн иргэн Л.Ууганбаяр	05.27- 10.25	10000,0	3330,0	6670,0
4	Зүүнбүрэн суманд	Өнөр төгөл ХХК	05.20- 10.25	10000,0	3330,0	6670,0
5	Сант суманд	Хушаат багийн иргэн Х.Хурметхан	05.28- 10.25	10000,0	3330,0	6670,0

	МҮГ байгуулах ажлын дүн			50000,0	16650,0	33350,0
--	------------------------------------	--	--	----------------	----------------	----------------

Аймгийн БОАЖГ-аас ойжуулалтын ажлын санхүүжилтийг шийдвэрлэж өгөхийг хүссэн албан тоотыг аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын СТСХ, ХБХ-т удаа дараа явуулсан боловч санхүүжилт хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар өнөөдрийг хүртэл олгоогүй байна.

Иймээс БХНС арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийн асуудлыг аймгийн ИТХ-аар шийдвэрлүүлэн, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Дөрөв. Илрүүлсэн зөрчил

Хийж гүйцэтгэсэн аудитаар дараах зөрчлүүдэд акт, албан шаардлага бичигдлээ.

1. Акт:

1. 2014 онд аймгийн БОАЖГ-ын ажилтнуудад томилолтын зардлыг илүү олгосон 309,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

2. Албан шаардлага:

1. Аймгийн БОАЖГ-ын дарга Б.Батзоригт томилолтын хуудас, томилолтын удирдамж, хийсэн ажлын тайлан зэрэг анхан шатны баримтгүйгээр олгосон шатахууны зардал 14358,2 мянган төгрөг / 2013 онд 5668,2 мянган төгрөг, 2014 онд 8690,0 мянган төг /
2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй 30000,0 мянган төгрөг / Ерөө сум /
3. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний санхүүжилтийг хуулиар тогтоосон хувь хэмжээнээс дутуу төлөвлөж, санхүүжүүлсэн 1783014,7 мянган төгрөг / 2013 онд 668700,0 мянган төгрөг, 2014 онд 1072065,2 мянган төгрөг /
4. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний санхүүжилтээр хийгдсэн ажлын санхүүжилтийг гэрээнээс дутуу олгосон 203616,4 мянган төгрөгийн зэрэг **нийт 2030989,3 мянган** төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага бичигдлээ.

Тав. Дүгнэлт

- ❖ БОАЖГ нь төсвийн төслийг урьд оны төсвийн гүйцэтгэл дээр үндэслэж, бодитоор төлөвлөөгүй байна.

- ❖ БОАЖГ-ын дарга нь тухайн байгууллагын нийт батлагдсан шатахууны зардлын 48,0 хувийг ганцаараа, 30,0 гаруй хувийг Улаанбаатарт ажиллахад зарцуулсан байна.
- ❖ Томилолт, шатахууны зардлын зарцуулалтад НББ-ээр тавих хяналт хангалтгүй байна.
- ❖ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тайлант оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож төлөвлөж, санхүүжүүлээгүй бөгөөд уг орлогын ихэнх хувийг төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.
- ❖ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөнд төсвийн байгууллагуудын урсгал зардал, хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлсэн байна.
- ❖ Тендерийн баримт бичгийн ТООЗ-нд заасан баримт материалын шаардлагыг хангаагүй аж ахуйн нэгжүүдийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна.
- ❖ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгоогүй, захиалагч гэрээний үүргээ зөрчсөн байна.

Зургаа. Аудитын зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат-д:

- ❖ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тухайн оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож бодитоор төлөвлөж, батлуулах.
- ❖ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний санхүүжилтээр төсвийн байгууллагуудын урсгал зардлыг нөхөж буй зөрчлийг арилгах.
- ❖ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний урьд оны дутуу санхүүжилтийг шийдвэрлэх.
- ❖ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний санхүүжилтээр хийж буй худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах.

Аймгийн БОАЖГ-ын дарга Б.Батзориг, нягтлан бодогч Б.Минжээ нарт:

- ❖ Төсвийн төслийг боловсруулахдаа урьд оны төсвийн гүйцэтгэл дээр үндэслэж, үнэн зөв тооцоолж, бодитоор төлөвлөх.
- ❖ Томилолт, шатахууны зардлын зарцуулалтад НББ-ээр тавих хяналтыг сайжруулах.

- ❖ Томилолтын хуудас, удирдамж, хийсэн ажлын тайлан зэрэг анхан шатны баримтыг үндэслэн шатахууны зардал олгож байх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

ШИНЖЭЭЧ

С.БААСАНСҮРЭН

ШИНЖЭЭЧ

Э.ЭРДЭНЭЗУЛ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: (976)-7036-3653

2015.11.16 № 395

танай _____-ны № _____-т


АЙМГИЙН АУДТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА ТАНАА

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ажилтан, албан хаагчдын томилолтын зардал хүрдэггүй учир тус газрын дарга Б.Батзориг нь 2013, 2014 онуудад томилолтын хуудас авч томилолтоор явдаг байсан ч томилолтын мөнгө авч байгаагүй.

Томилолтын хуудаснууд нь үрэгдэж алга болсноос шалтгаалан анхан шатны баримт дутуу харагдаж байгаа болно. Тус газраас анхан шатны баримт болох томилолтын хуудсыг бүрдүүлэхийн тулд аймгийн ЗДТГ-ын бичиг хэргийн ажилтанд хандсан боловч дугаараар шүүх боломжгүй гэсэн хариу өгсөн.

Цаашид ийм асуудал гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах болно.

ДАРГА



Б.БАТЗОРИГ

alban bichig /jijig /

